



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/31

Чихэртэй

Наурыз баярыг тэмдэглэн өнгөрүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Казак ард түмний уламжлалт Наурызын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	А.Озат	- Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	О.Сакен	- Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Е.Аххундыз	- Хууль, эх зүйн мэргэжилтэн
	А.Серикжан	- Биеийн тамир, спортын ажил хариуцсан ажилтан
	К.Исламбек	- Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга
	А.Яков	- Хөдөө аж ахуйн мэргэжилтэн
	С.Шаймардан	- Засаг даргын Тамгын газрын нярав
	Б.Шынасыл	- Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
	С.Нурбек	- Бөхийн холбооны гишүүн
	А.Ахтан	- 1 дүгээр багийн Засаг дарга
	Х.Хумырбек	- 3 дугаар багийн Засаг дарга
	Х.Танатар	- 4 дүгээр багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Х.Саттигүл - Соёлын төвийн эрхлэгч

2. Наурызын баярын үйл ажиллагааг соёлын өндөр түвшинд зохион байгуулан баярын хөтөлбөр гаргаж, сурталчилж үндэсний хувцастай 7 хоногийн аян зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлэхийг комиссын дарга А.Озат-д баярын үеээр харуул хамгаалалтыг өндөржүүлсэн бэлэн байдалтай байлган, гэмт хэргээс урьдчилан сэргийлэн хариуцлагатай ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч Б.Шынасыл болон албан байгууллагын дарга болон багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.